



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ-ын 2021оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БНА-2022/7/НА-СТА-ОНӨААН**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Баянхонгор 2022 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: <a href="mailto:Munkhbatb@audit.gov.mm">Munkhbatb@audit.gov.mm</a></p> <p>Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: <a href="mailto:TseenyamA@audit.gov.mm">TseenyamA@audit.gov.mm</a></p> <p>Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг: <a href="mailto:Altantuyam@audit.gov.mm">Altantuyam@audit.gov.mm</a></p> <p>Аудитор: Л.Доржханд Утас: 99093683 Цахим хаяг: <a href="mailto:dorjkhndl@audit.gov.mn">dorjkhndl@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
/төгрөгөөр/ .....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	4
/төгрөгөөр/ .....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
/төгрөгөөр/ .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
/төгрөгөөр/ .....	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	7
3.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	7
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	8
4. Аудитын тайлан .....	9
4.1 Ерөнхий зүйл .....	9
4.2 Дотоод хяналт .....	10
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
4.4 Материаллаг байдал .....	10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	11
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
8. Аудитын илрүүлэлт .....	12
8.1 Төлбөрийн акт .....	12
8.2 Албан шаардлага .....	13
8.3 Зөвлөмж .....	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	0

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.03.15 № 2/149

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Цэвэр хот ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь” Хязгаарлалттай дүгнэлт” өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Цэвэр хот ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс мөн АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Нярвын тайлангаар бараа материалын сэлбэг хэрэгслийн орлогыг 34,929.9 мянга, зарлагыг 30,111.0 мянган төгрөгөөр бүртгэсэн байхад нягтлан бодогч нь санхүүгийн тайланд сэлбэг хэрэгсэл дансны орлогыг 9,711.6 мянга, зарлагыг 11,534.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна
- Нягтлан бодогч нь анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгасан, нярав кассын тайлан гаргаагүй, бараа материалын тайланг холбогдох журам, стандартын дагуу бэлтгэж гаргаагүй, анхан шатны баримтыг санхүүгийн баримтад бүрэн хавсаргаагүй.

D:\2022-A4 тоот.docx

• 005020646

- Урд оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн акт 2,630.0 мянган төгрөгийг барагдуулахдаа байгууллагын төсвөөс төлсөн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна. 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.2.6.дахь “Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, санхүүгийн тайлангийн “Бодитой оршин байх”, “Үнэлгээ ба хуваарилалт”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>21,855,221.69</b>	<b>58,156,176.33</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>26,764.23</b>	<b>22,547,794.76</b>
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	26,764.23	22,547,794.76
31210	Төгрөг	26,764.23	22,547,794.76
31213	Арилжааны банк дахь харилцах	26,764.23	22,547,794.76
33	<b>АВЛАГА</b>	<b>2,534,590.16</b>	<b>2,534,590.16</b>
33500	<b>Бусад авлага</b>	<b>2,534,590.16</b>	<b>2,534,590.16</b>
33510	Байгууллагаас авах авлага	2,534,590.16	2,534,590.16
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>19,293,867.30</b>	<b>33,073,791.41</b>
35400	<b>Хангамжийн материал</b>	<b>19,293,867.30</b>	<b>31,693,791.41</b>
35420	Аж ахуйн материал	19,293,867.30	31,693,791.41
35600	Мал амьтад	0	1,380,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>101,148,309.20</b>	<b>185,438,112.74</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>101,148,309.20</b>	<b>185,438,112.74</b>
39200	Биет хөрөнгө	101,148,309.20	185,438,112.74
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>123,003,530.89</b>	<b>243,594,289.07</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>51,882,192.08</b>	<b>278,000.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>51,882,192.08</b>	<b>278,000.00</b>
41300	<b>Өглөг</b>	<b>51,882,192.08</b>	<b>278,000.00</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	51,882,192.08	278,000.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>71,121,338.81</b>	<b>243,316,289.07</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>71,121,338.81</b>	<b>243,316,289.07</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	489,560,447.00	612,440,438.00
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-418,439,108.19</b>	<b>-369,124,148.93</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-418,439,108.19	-418,439,108.19
51220	Тайлант үеийн үр дүн		49,314,959.26
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>123,003,530.89</b>	<b>243,594,289.07</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>585,777,000.00</b>	<b>740,059,901.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>585,777,000.00</b>	<b>740,059,901.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	585,777,000.00	740,059,901.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>585,777,000.00</b>	<b>740,059,901.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	585,777,000.00	740,059,901.00
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>645,651,529.63</b>	<b>690,744,941.74</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>645,651,529.63</b>	<b>690,744,941.74</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>645,651,529.63</b>	<b>690,744,941.74</b>
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>645,651,529.63</b>	<b>690,744,941.74</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	620,907,578.05	651,885,745.28
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,743,951.58	38,859,196.46
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-59,874,529.63</b>	<b>49,314,959.26</b>

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-59,874,529.63	49,314,959.26
----	--	----------------	---------------

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	401,066,447.00	0	-270,070,578.57	130,995,868.43
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-88,493,999.99	-88,493,999.99
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	401,066,447.00	0	-358,564,578.56	42,501,868.44
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	88,494,000.00	0	0	88,494,000.00
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-59,874,529.63	-59,874,529.63
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	489,560,447.00	0	-418,439,108.19	71,121,338.81
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	489,560,447.00	0	-418,439,108.19	71,121,338.81
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	489,560,447.00	0	-418,439,108.19	71,121,338.81
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	122,879,991.00	0	0	122,879,991.00
19	Тайлант үеийн үр дүн	0	0	49,314,959.26	49,314,959.26
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	612,440,438.00	0	-369,124,148.93	243,316,289.07

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	585,777,000.00	740,059,901.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	585,777,000.00	740,059,901.00
120	Нийтлэг татварын бус орлого	585,777,000.00	740,059,901.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	585,777,000.00	740,059,901.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	585,777,000.00	666,242,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	73,817,601.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	585,769,035.97	714,499,870.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	585,769,035.97	714,499,870.47

210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>585,769,035.97</b>	<b>714,499,870.47</b>
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>585,769,035.97</b>	<b>714,499,870.47</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	585,769,035.97	714,499,870.47
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>7,964.03</b>	<b>25,560,030.53</b>
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>0</b>	<b>3,039,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0</b>	<b>3,039,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0</b>	<b>3,039,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	3,039,000.00
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>0</b>	<b>-3,039,000.00</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>7,964.03</b>	<b>22,521,030.53</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,800.20	26,764.23
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,764.23	22,547,794.76

**2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	733,526,100.00	717,538,870.47	15,987,229.53	97.8
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	733,526,100.00	717,538,870.47	15,987,229.53	97.8
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	728,536,100.00	709,548,870.47	18,987,229.53	97.4
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	367,558,100.00	342,659,151.47	24,898,948.53	93.2
210101	Үндсэн цалин	367,558,100.00	342,659,151.47	24,898,948.53	93.2
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	79,470,900.00	114,038,023.00	(34,567,123.00)	143.5
210201	Тэтгэврийн даатгал	79,470,900.00	114,038,023.00	(34,567,123.00)	143.5
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7,701,200.00	7,027,393.00	673,807.00	91.3
210301	Гэрэл, цахилгаан	1,757,200.00	1,372,493.00	384,707.00	78.1
210302	Түлш, халаалт	2,600,000.00	2,494,900.00	105,100.00	96.0
210303	Цэвэр, бохир ус	264,000.00	80,000.00	184,000.00	30.3
210304	Байрны түрээс	3,080,000.00	3,080,000.00	-	100.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	209,350,200.00	146,942,057.00	62,408,143.00	70.2
210401	Бичиг хэрэг	3,168,400.00	2,318,760.00	849,640.00	73.2
210402	Тээвэр, шатахуун	202,250,800.00	141,276,170.00	60,974,630.00	69.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,372,800.00	1,258,627.00	114,173.00	91.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,558,200.00	2,088,500.00	469,700.00	81.6

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	11,660,000.00	11,415,770.00	244,230.00	97.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,660,000.00	11,415,770.00	244,230.00	97.9
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	42,947,100.00	68,234,796.00	(25,287,696.00)	158.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,453,500.00	8,220,050.00	(2,766,550.00)	150.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,893,600.00	11,893,600.00	-	100.0
210604	Урсгал засвар	25,600,000.00	48,121,146.00	(22,521,146.00)	188.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,274,000.00	1,274,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	1,274,000.00	1,274,000.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,174,600.00	6,633,680.00	(459,080.00)	107.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	560,000.00	998,880.00	(438,880.00)	178.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,124,500.00	1,124,500.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	462,000.00	540,000.00	(78,000.00)	116.9
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,678,100.00	3,620,300.00	57,800.00	98.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,400,000.00	11,324,000.00	(8,924,000.00)	471.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	8,924,000.00	(6,524,000.00)	371.8
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4,990,000.00	7,990,000.00	(3,000,000.00)	160.1
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,990,000.00	7,990,000.00	(3,000,000.00)	160.1
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,990,000.00	7,990,000.00	(3,000,000.00)	160.1
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	700,000,000.00	740,059,901.00	(40,059,901.00)	105.7
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	150,000,000.00	159,800,000.00	(9,800,000.00)	106.5
132001	Орон нутгийн төсвөөс	150,000,000.00	150,000,000.00	-	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	550,000,000.00	580,259,901.00	(30,259,901.00)	105.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	550,000,000.00	516,242,300.00	33,757,700.00	93.9

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ нь 2021 онд дэвшүүлсэн үндсэн зорилт, менежментийн ерөнхий төлөвлөгөөг удирдлага болгон нийт нутаг дэвсгэрийнхээ хог хаягдлыг нэгдсэн цэгт төвлөрүүлэх, аж ахуйн нэгж иргэдийн хог хаягдлыг стандартын дагуу тээвэрлэх цэвэр орчныг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх зорилтыг тавин ажиллаж байна.

Цэвэр хот ОНӨААТҮГ-ын зорилго нь “Аюулгүй ажиллагааг эрхэмлэн ард түмний итгэл найдварыг алдахгүй, түргэн шуурхай үйлчилгээг ард түмэнд хүргэж ажиллах” -д оршино.

Мөн гэр хорооллын 7398 айл өрх орон сууцны 1325 айл өрх, төрийн болон хувийн хэвшил аж ахуйн нэгж 187 байгууллага иргэдийн хог хаягдлын тээвэрлэж байна.

### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Цэвэр хот ОНӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй, Сангийн яамны шаардлага хангасан аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан гаргадаг санхүүгийн программ хангамж ашиглаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Цэвэр хот ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	21,855.2	58,156.2	36,301.0
Мөнгөн хөрөнгө	26.8	22,547.8	22,521.0
Авлага	2,534.6	2,534.6	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	19,293.9	33,073.8	13,779.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	101,148.3	185,438.1	84,289.8
Үндсэн хөрөнгө	499,223.8	590,756.8	91,533.0
Хуримтлагдсан элэгдэл	(398,075.5)	(405,318.7)	(7,243.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>123,003.5</b>	<b>243,594.3</b>	<b>120,590.8</b>
Өр төлбөр	51,882.2	278.0	(51,604.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	71,121.3	243,316.3	172,195.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>123,003.5</b>	<b>243,594.3</b>	<b>120,590.8</b>

Эх сурвалж: 2021 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 22,547.8 мянган төгрөг болж 22,521.0 мянган төгрөгөөр өссөн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр шилжүүлсэн санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Хаан банкны 5249036765 тоот харилцах дансанд үлдэгдлээр байршуулсантай холбоотой байна.

Өмнөх оны авлага 2,534.6 мянган төгрөг нь Татварын хэлтсээс авах НӨАТ-ын авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 33,073.8 мянган төгрөг болж 13,779.9 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 319.8 мянга, аж ахуйн материал 9,031.7 мянга, сэлбэг хэрэгсэл 2,996.5 мянга, мал амьтад 1,380.0 мянган өссөнтэй холбоотой бөгөөд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 205,451.7 мянган төгрөгийн бараа материалыг орлого авч 193,051.7 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 590,756.8 мянган төгрөг болж 91,533.0 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/ 436 дугаартай захирамжийн дагуу аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр “Талын нөмөр” ХХК-наас нийлүүлсэн 119,800.0 мянган төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг өөрөө буулгагч автомашин, бараа материалын данснаас шилжүүлэн бүртгэсэн 310,0 мянган төгрөгийн ширээ, сандал, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,039.0 мянга, нийт 123,149.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлого авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 10 дугаар тогтоолын дагуу 31,616.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг акталж сэлбэгээр ашигласантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 278.0 мянган төгрөг болж 51,604.2 мянган төгрөгөөр буурсан нь НДШ-ийн өр 24,329.4 мянга, Татварын хэлтэстэй холбоотой ХХАОТ-ын өр 19,155.5 мянга, Шунхлай трейдинг ХХК-тай холбоотой шатахууны өр 8119.3 мянган төгрөгийн өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 243,316.3 мянган төгрөг болж 172,195.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 172,195.0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### **3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт Хог хаягдлын тухай хуулийн дагуу санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Байгууллагын техник, эдийн засгийн гол үзүүлэлт нь Баянхонгор аймгийн хог хаягдлыг төвлөрсөн журмаар ачиж тээвэрлэн нэгдсэн хогийн цэгт хүргэх, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулж ашиглахтай холбоотой иргэд, аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэн хог хаягдлыг ангилан ялгах цуглуулахтай холбоотой харилцааг зохицуулж, байгаль орчинд ээлтэй цэвэр орчныг бүрдүүлэх явдал юм.

Баянхонгор сумын ИТХ-ын 2020 оны хуралдаанаар 2021 оны орлогын төлөвлөгөөг анх 700,000.0 мянга, зарлагыг 700,000.0 мянган төгрөгөөр баталсан ба 2021 онд орлогыг 33,526.1 мянган төгрөгөөр нэмж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр хог хаягдлын хураамж тэглэсэнтэйгээр холбоотой Сангийн яамны санхүүжилтээр 516,242.3 мянга, санхүүгийн дэмжлэгээр 150,000.0 мянга, орон сууцны хог хаягдлын хураамжийн орлого 64,017.6 мянга, ОНХС-аас нохой устгалын санхүүжилт 9,800.0 мянга нийт 740,059.9 мянган төгрөгийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нийт орлогын гүйцэтгэл 733,526.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 6,533.8 мянган төгрөг буюу 0.8 хувиар нэмэгдсэн нь орон сууцны орлого биелсэнтэй холбоотой байна.

## **4. Аудитын тайлан**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг захирал Ц.Баясгалан танд танилцуулж байна

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад орон нутгийн өмч түүний зарцуулалт, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 15-ны өдөр ирүүлсэн.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Цэвэр хот ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 149 дүгээр тогтоолоор ТУЗ-ыг 9 гишүүний бүрэлдэхүүнтэй баталсан боловч ТУЗ нь анхны хуралдаанаа зохион байгуулаагүй байна.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулахдаа нэгдүгээр гарын үсгийг “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын захирал Ц.Баясгалан, нягтлан бодогч Л.Баттөмөр хоёрдугаар гарын үсгийг зурсан байна.

#### **4.2 Дотоод хяналт**

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээр илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **4.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу

илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 690,744.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,361.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,252.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангаар тооцсон тул аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ нь 2021 онд цахим хуудаст ил тод 996,917.8 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас 770,638.4 мянган төгрөгийн 138 мэдээллийг хугацаандаа байршуулж 226,279.4 мянган төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Хүснэгт 2. Шилэн дансны мэдээлэл оруулсан байдал

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	33	3	
5	Тухай бүр	8	96	88	8	
	Нийт	27	151	138	11	2

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн системээс

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж өгөв.

### 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 79,114.92 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3250.5 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 5745.02 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 66,649.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 3,470.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөрчил арилгах 2 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг “Цэвэр хот” ОНӨААТҮГ -ын 2021.06.15-ны өдрийн 46 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Санхүүгийн тайланд залруулсан	1	3250.5	1	3250.5			
Төлбөрийн акт	3	5745.02	2	3115.02	1	2,630.0	45.7
Албан шаардлага	1	66,649.0	1	66,649.0	0	0	0
Зөвлөмж	2	3,470.4	2	3,470.4			
Нийт дүн	7	79,114.92	6	76,484.92	1	2,630.0	0

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын статистик мэдээ

Төлбөрийн акт тогтоосон 2,630.0 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс төлж барагдуулсан боловч тухайн байгууллагад буцаан тушаагаагүй байна.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагуудтай хог тээвэрлэх гэрээ байгуулсан боловч гэрээг дүгнээгүй, Нягтлан бодох бүртгэлд гэрээний дүнг авлагаар бүртгэдэггүй, ААНБ-ын орлогыг бэлэн мөнгөний баримт бичин хураан авч байгаа боловч бүртгэлээр тавих хяналт байхгүй, сар бүр кассын тайлан гаргаж, үйлчлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдээгүй байгаа нь хог тээврийн орлогод байгууллагын бүртгэлээр тавих хяналт сул байгааг харуулж байна.

Цаашид хог тээврийн орлогын гүйцэтгэлд завсрын аудит хийж ААНБ-тай орлогын тулгалт хийх шаардлага гэж үзэж байна.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 253,576.9 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 2,630.0 мянган төгрөгийн 1 алдаанд төлбөрийн акт, 1 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 250,946.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн материаллаг алдаа нь гүйцэтгэлийн шатанд тооцсон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөв.

### 8.1 Төлбөрийн акт

1.Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн акт 2630,0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг холбогдох ажилчдаас суутган тооцоогүй байгууллагын төсвөөс төлж, зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.”эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч,

худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, санхүүгийн тайлангийн “бодитой оршин байх”, “Эрх ба үүрэг” Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь.

Өмнөх оны актын төлбөр 2,630.0 мянган төгрөгийг байгууллагын дарга, нягтлан бодогч нараар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 8.2 Албан шаардлага

1. “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагуудтай хог тээвэрлэх гэрээ байгуулсан боловч гэрээг дүгнээгүй, үйлчлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдээгүй, сар бүр кассын тайлан гаргаагүй зэрэг нь байгууллагын бүртгэлээр тавих хяналт сул байгаад анхаарч ажиллах талаар аудитын анхаарал татахуйц асуудалд тайлагнасан байхад тайланд онд дээрх алдаанууд давтагдан гарсаар байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1. “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Үнэлгээ ба хуваарилалт”. “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтагдан гарч аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй тул “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын захирал Ц.Баясгаланд хариуцлага тооцуулах саналыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

## 8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нярав бараа материалын сэлбэг хэрэгслийн тайланг гаргахдаа орлогыг 34,929.9 мянга, зарлагыг 30,111.0 мянган төгрөгөөр бүртгэсэн байхад нягтлан бодогч нь санхүүгийн тайланд сэлбэг хэрэгсэл дансны орлогыг 9,711.6 мянга, зарлагыг 11,534.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. Нягтлан бодогч нь анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.4. Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна. 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. санхүүгийн тайлагналын “Оршин байх”, “Үнэлгээ ба хуваарилалт”. “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй.

Өгсөн зөвлөмж

Санхүүгийн тайлангийн бараа материалыг тодруулга болон нярвын бараа материалыг тайланг анхан шатны баримтын дагуу үнэн зөв бэлтгэх талаар зөвлөмж хүргүүлээ.

2. Нярав Г.Нацагюмсүрэнгийн дансаар 14,089.4 төгрөгийг шилжүүлж хөрөнгийг зарцуулахдаа кассын тайлан гаргаагүй бараа бүтээгдэхүүн худалдаж авсан анхан шатны баримт байгаа боловч ебаримтаар баталгаажаагүй байна.

Энэ Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Бараа материал, сэлбэг хэрэгслийн худалдан авахдаа бэлтгэн нийлүүлэгчээс НӨАТ-ын ебаримтыг үндэслэн санхүүгийн гүйлгээ хийх, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

3. Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ нь 2021 онд цахим хуудаcт ил тод 996,917.8 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас 770,638.4 мянган төгрөгийн 138 мэдээллийг хугацаандаа байршуулж 226,279.4 мянган төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ зэрэг 14 мэдээллийг хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

4.Тус байгууллага нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 7,701.2 мянган төгрөгөөр баталж 7,027.4 мянган төгрөгийг зарцуулж нийт 1,540.2 мянган төгрөг хэмнэхээс 673.8 төгрөгийг хэмнэж 866.4 мянган төгрөгийг хэмнээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид Засгийн газраас гаргасан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
					Санхүүгийн тайлангийн асуудлаар												
1	Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ	БНА-2022/7/НА-СТА-ОНӨААН	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоосон 2630,0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг холбогдох ажилчдаас суутган тооцоогүй актын төлбөрийг байгууллагын төсвөөс төлсөн байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6."эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8."төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", санхүүгийн тайлангийн "бодитой оршин байх", "Эрх ба үүрэг" Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул 2,630.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.					1	2,630.0							
2	Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ	БНА-2022/7/НА-СТА-ОНӨААН	Баянхонгор аймгийн "Цэвэр хот" ОНӨААТҮГ нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар "Ажиллагсдад олгосон 2630,0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг нэр бүхий хүмүүсээр нөхөн төлүүлэх" зэр 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 106-АО560237-БНА-2021/7/СТА-ОНӨААН дугаартай төлбөрийн акт тогтоосныг байгууллагын төсвөөс төлж	Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1."Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэт рүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн									1				







БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 100/А0570643-БНА  
2022/7/СТА-ОНӨААН

Номгон

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Ажиллагсад олгосон 2630,0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг нэр бүхий хүмүүсээр нөхөн төлүүлэх”-ээр 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 106-А0560237-БНА-2021/7/СТА-ОНӨААН дугаартай төлбөрийн акт тогтоосныг байгууллагын төсвөөс төлж зардлаар бүртгэсэн.

2. Мөн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагуудтай хог тээвэрлэх гэрээ байгуулсан боловч гэрээг дүгнээгүй, үйлчлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдээгүй, сар бүр кассын тайлан гаргаагүй, нягтлан бодогч нь анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгасан байхад хяналт тавиагүй зэрэг алдаанууд тайланд онд дахин давтагдан гарсаар байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1. “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэхь “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн

d:\2022.албан шаардлага.docx

• 035040262

акт тогтоох журам"-ын 4.2.1.11 дахь "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн актыг байгууллагын төсвөөс төлж зардлаар бүртгэсэн, мөн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагуудтай хог тээвэрлэх гэрээ байгуулсан боловч гэрээг дүгнээгүй, үйлчлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдээгүй, сар бүр кассын тайлан гаргаагүй, нягтлан бодогч нь анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгасан зэрэг алдаанууд тайланд онд дахин давтагдан гарсаар байхад өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг тооцоогүй тул "Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын захирал Ц.Баясгаланд хариуцлага тооцуулах саналыг аймгийн Засаг даргад хүргүүлэх.

2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг аймгийн Засаг дарга Д.Мөнхсайханд хариуцуулав<sup>2</sup>.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН <sup>3</sup>:**  
**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

АУДИТОР

Л.ДОРЖХАНД

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 114/A0570643-511А  
2022/7/СТА-ОНӨААК

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоосон 2,630,000.00 төгрөгийн цалингийн урьдчилгааг холбогдох ажилчдаас суутган тооцоогүй актын төлбөрийг байгууллагын төсвөөс төлж зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.”эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.”төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, санхүүгийн тайлангийн “бодитой оршин байх”, “Эрх ба үүрэг” Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийг 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын захирал Ц.Баясгалан, Л.Баттөмөр нараар өмнөх оны актын төлбөр 2,630,000.00 /Хоёр сая зургаан зуун гучин мянган/ төгрөгийг тус байгууллагын Хаан банкин дахь 5249036765 тоот дансанд төвлөрүүлэх.

d:\2022.акт.docx

005050315

2.Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2022 оны 06 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын захирал Ц.Баясгалан, Л.Баттөмөр нарт хариуцуулав<sup>1</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>2</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР  А.ЦЭЭНЯМ

АУДИТОР  Л.ДОРЖХАНД

6417-49544  
B-0A08E7 9007423

<sup>1</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

<sup>2</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно